

## МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН БОДЛОГО

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн бодлого нь технологи ашигласан зээлийн үйл ажиллагаа, санхүүгийн үйлчилгээ, хэрэглэгч, хамтран ажиллах байгууллагын мэдээллийн нууцлал, хүртээмжтэй байдал, бүрэн байдлыг хангах зорилгоор ISO27001 стандартын дагуу Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хянах, тасралтгүй сайжруулахаар зорьж ажиллана.

Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын хүрээнд дараах зарчмуудын баримталж ажиллана. Үүнд:

### **1. Мэдээллийн систем, Мэдээллийн сүлжээ, Мэдээллийн дэд бүтцийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангах:**

Компанийн мэдээллийн хөрөнгө нь Компанийн өмч бөгөөд тухайн мэдээллийн бодит болон Кибер орчинд нууцлагдсан, бүрэн бүтэн байдлыг чанд хамгаалахыг зорьж ажиллана.

### **2. Хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын шаардлагыг хангах:**

Мэдээллийн аюулгүй байдлыг менежментийн тогтолцоо хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын хууль, тогтоомж, төрийн зохицуулагч байгууллагын журам, эрхзүйн акт болон олон улсын стандартын шаардлагад нийцүүлж ажиллана.

### **3. Бизнесийн тасралтгүй байдлыг хангах:**

Компанийн харилцагч, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, хамтран ажиллагч, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллахдаа, бизнесийн үйл ажиллагааны тогтвортой тасралтгүй байдал, кибер орчны мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангаж ажиллана.

### **4. Бизнесийн харилцаа дахь мэдээллийн аюулгүй байдлыг хангах:**

Хамтрагч, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, нийлүүлэгч, хөндлөнгийн аудит, үүрэн холбоо, банк, төсөл хэрэгжүүлэгч, холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага зэрэг төрийн болон төрийн бус, хувийн байгууллагуудтай хамтарч ажиллахдаа мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны дагуу гэрээний шаардлагыг тавьж ажиллана.

### **5. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх:**

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг компанийн “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ын дагуу удирдаж, хэрэгжүүлнэ